Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2019]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in any way. [UM] is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Оффшор болгон бууруугүй

"Оффшор сан ажиллуулагсад эх орондоо татвараа төлөхгүй байгаа нь эвшээрч боломгүй зүйл. > 10

Болгоомж төрүүлж буй уулзалт

АНУ-ын 71 настай төрүүн, Филиппиний 72 настай удирдагч хоёрт тестэй тал мундахгүй. > 10

Alibaba ганц бие хүмүүсийн өдөр шинэ амжилт тогтоов

Тус компани энэ жил олон улсын эх хэлэ, дотоодын хэрэв нутагт илүү анхаарал хандуулж байна. > 10

Номхон далайн орнууд худалдааны шинэ гэрээ байгуулна

Шон Доннан

Номхон далайн бүсийн 11 улс худалдааны гэрээний гол элементүүдийг энэ үдээний үдэшлэг дээр АНУ-гүйгээр шинэ гэрээ байгуулах төлөлцөөнд хүрээ. Үүнд оюуны өмчийг хамгаалах тэргүүн өөнө нь Вашингтоны санал болгож байсан асуудлууд багтаж. Японы болон бусад 10 орны сайд нар Вьетнамд болсон Ази, Номхон далайн хэлбэ тасгийн чуулганы үеэр гэрээнд шинэ нэр өгөхөөр тохиролцсоо. TPP гэдэг нэрээ байсныг CPTPP хэмээн бүх нийтийн хамарсан, дэвшилт хоёр уг нэмж шинээр нэрлэсэн байна. Ерөнхийлөгч Дональд Трамп худалдааны хэлдлагаа өөрчлөх үүднээс инэгүүлэр сард уг гэрээнээс татгалзсан билээ. Вьетнамын Үйлдвэр худалдааны сайд Тран Туан Ан хэлэлцээ шинэ гэрээг TPP-ын үргэлжлэл хэмээн онцлов.

Тэрбээр "12 гишүүнтэй TPP-ээс нэг улс гарсан учир үлдэгч орнууд энэ чиглэлээр зэмнэхээ илэрхийллээ" гэжээ. Гэвч бусад 11 орон гол зарчмуудыг тохиролцоход цаг хугацаа шаардлагатайг хүлээн зөвшөөров. АНУ-ын өмнөх засаг захиргаа гэрээг хэлэлцэхэд олон жилийг зарцуулсан атал нөөн Трамп бүхнийг орхисон тул гадна үлдээ. Японы Эдийн засгийн сайд Тошимицу Мотеги шинэ гэрээ TPP-ын 20 гүйлийг авс үлдэж буйгаас 11 нь оюуны өмчтэй холбоотой хэмээн тайлбарласан байна. Тэрбээр "Үлийг нийт 11 орон зөвшөөрөх ёстой. Энэ санаачлага АНУ болон Ази, Номхон далайн улсуудад хүчтэй мессеж хүргэх болно" гэсэн юм.

Түүний хэлснээр наад зах нь зургаан улс нөөлөх журмыг гүйцэтгэснээс хойш 60 хэмжээг дотор уг гэрээ хэрэгжих эсэх зорилт тавьсныг мэдээлэв. Нөөн Тран Туан Ан "Хүчд хамаг ардаа өрсөлөө. Одоо CPTPP руу шуурч алхаж байна. Бид нрөлүүдээ үлээхээр интэлтэй байгаа" хэмээн онцлоо.

АНУ TPP-ээс гарсан болсон



ВВМС

Японы гэрээнд дэх хамтрын том эдийн засаг болох ба нийлээд 500 сая хүн амьт хамарч, дэлхийн эдийн засгийн 13 хувь буюу 10 их наяд ам долларын бүтээгдэхүүн гаргана. Түүнчлэн Өмнөд Солонгос, Индонези гээг улс нрөлүүдийг элсэх сонирхлоо илэрхийллээ. Гэрээний нэрийг өөрчлөснээ Канадын Ерөнхий сайд Жастин Трюдогийн санаал тулгуурласан бөгөөд тэрбээр энэхүү гэрээ худалдааны дэвшилтэт зарчмыг ачуулсан гэж үзэж байгаа аж. Нөөн Трюдо "Канад улс гадаад, дотоодод нээлттэй, дэвшилт худалдааны зарчмыг мөнөө хамгалж хугацаа хэлэлцээс хойш гүйцэлтүй мэдэж байна" хэмээн мэдэгдэв.

Гол хэлэлцэх хүлээгдэж буй хэдий ч шинжээчид үнэдсэн ачуудыг шийдэхгүй боломжгүй биш учир хэдэн сарын дотор гарын үсэг тураг, нрөх оноос хэрэгжүүлж эхлэх болов уу хэмээн дүгнэсэн байна. Синлэйр дахь Алибэ худалдааны тоинйн захирал Дебора Элмс "Энэ гэрээ TPP ч багтсаныг дахин болно. Тэд ганц долоо хоногийн дотор тохиролцоонд хүрч чадсан нь бйр сууть нь ямар өйртсөнөг харуулна" хэмээн тайлбарлажээ. Харин Канадын франкофон ярьдаг Квебек мужаа онцгой нөөдөл олгох хүсэлт гаргасан байна. Малайз, Бруней улсын хувьд улсын хөрөнгө оруулалтай том компаниудад нөлөөлөх журмыг хойшлуулах санал тавилаа.

Нөөн Трюдо "Хийх зүйл их байгаа. Би долоо хоногийн турш гэрээг яаралчлах хэрэгтэй гэдгийг сануулсан" гэв. Нарийн түвэгтэй гэрээг 11 улс дахин хэлэлдрж, АНУ-ын санаачлаг оруулсан болович бусад орон эсэргүүцэл өгүүлбэрийг хүргэх шинээр томьёолох шаардлага үүссэн байна. Тухайлбал, биологийн эмийн патентийг хамгалах, эсвэлч нь нас барснаас хойш 70 жилийн турш оюуны өмчийн эрхийг хадгалах гэх мэт маргаантай асуудал шийдэх хүлээх байгаа ком байна. FT

ВВМС

Шинэ Делийн утаа Бээжингийнхээс дор

Киран Стейси

Энэ долоо хоногт Энэтхэгийн хойд нутгийг нөмөрсөн өтөн утаанд хэн нэгнийг буруутган улстөрчид нь маргалдах завсар ард нрөлдаагаар нь жил нрөх тутам цэвэршик бүй Хятадыг ятаархан харж байна. Улс төрийн төцөөний нимгэт шинэдэгүй тул Бээжин агаарын бохирдлын асуудлыг илүү амжилттай шийдэж байна гэж үзэх хүн олон. Тэд тус улсын хурц мөртөө үр дүнгүй ардчиллыг үүнд буруутгадаг. Гэвч шинжээчдийн дүгнэлтээр Хятад сүүлийн хэдэн жил агаарын чанар сайжирсан болон бохирдол дахин нэмэгдэх нь улс төрөөс гадна эдийн засгийн хүчин үүйл чухал болохыг харуулж байна.

Энэтхэгийн гол мөрөн, агаарын бохирдлын түвшин нэлээд доогуур тул жилд бохирдлоос шалтгаалсан үхэл есөн сая хүрснийг Analytis Environment байгууллага мэдээлэв. Энэ долоо хоногт Шинэ Делид агаарын бохирдол хэрэгс хэтэрч, АНУын ЭСЯ-ны агаарын чанарын индекээр 999 гэсэн тоо заасан байна. Энэ индекээр 100-аас дээш гарахад эрүүл биш гэж үздэг. Гэтэл өнгөрсөн лхагва гарагт Делид PM2.5 хэмээх хорт бөөм сая 833 гэж бүртгэдсэн бол Бээжинд 76 байв. Энэ үзүүлэлт 50-аас гарахад эрүүл биш, 300-аас дээшийхэл аюултай гэж тооцдог.

Сүүлийн жилүүдэд Делид дэлхийн хамгийн бохирдолтой мегахот гэдэг нэрийг Бээжингээс авснаас хойш нйм ялгаа улам нэмэгдлээ. Бээжингийн их сургуулийн судалгаанаас үзэхэд 2013-2016 оны хооронд энд PM2.5-ын түвшин 27 хувь буурсан байна. Делигийн хувьд уг үзүүлэлтийн судалгаа байхгүй. Гэхдээ манай сонин бэлэн мэдээллийг харьцуулж үзэхэд мөн хугацаанд Делид PM2.5 12 хувь өссөн гэсэн дүнолт хүрсэн юм. Энэ дүнолт хотын түүхэнд хамгийн өндөр бохирдолтой гэж тооцогдсон өнгөрсөн өвөл багтаагүй юм. Үүний зэрэцүү хүчийн давсар ихэвчлэн хэмээх ч нөмөрсөн байна.

Scientific Reports сэтгүүлийн сүүлийн дугаарт нийтлэгдсэн 2007 оноос хойшхи судалгаанаас үзэхэд Хятадад SO2-ын ялгаруулалт 75 хувь буурсан бол Энэтхэг 50 хувиар дэлшсэн ак. Энэ байдал хотын иргэдийн уур бүлэмдлыг төрүүлж, асуудыг шийдэх чадагүй улстөрчдийг буруутгах байгаа юм. Observer Research Foundation-ы ахлах судлаач Вивром Матур "Энэтхэг Хятад хоёрын ялгаа нь энд улс төрөөс давсан асуудал болоод байна. Яагаа ног зүйлийг хойлойн өөнө улстөрчид, нямүү, мужууд хоорондоо холхидэх төхөрөх хэрэгтэй болдог" хэмээн шүмэлэв. Хотын ерөнхий сайд Арвинд Кежривал сүргуулийн хэмээлийг эсгээсэх, машинаар дугаараар явуулах шийдвэр гаргахаа өмнө агаарын бохирдлыг гаднаа комертай үүйлсэн билээ. Тэрбээр утаанд голүүсвийнээс болох будааны ишийг шатаадаг яйдлыг хэрхэн эсгээсэх талаар Конгресс нөөлөн хууль тогтоогч Америкчдэр Сенатэгт твиттерээр мэргэдэлд ашсан байна.

Харин Хятадын хувьд алвина асуудлын талаар улс төрийн бодлогыг маш хялбар зөвшилдөг агаад ган ба нүүрсний үйлдвэрлэлийг таних буюу эсгээсэх санамж бичиг хүргүүлээд шийдчих жишээтэй. Тухайлбал, тус улс энэ өвөл ган үйлдвэрлэгчдэд гарцаа 50 хувиар бууруулах тушаал өгсөн. Түүнчлэн сакан байгаль орчны хяналт нвуулж, хаяийн бүтээдэхүүн, цемент, резинэй гэх мэт хэдэн арван мянган үйлдвэрийг хаалга. Гэхдээ Бээжингийн агаарыг цэвэр байлгах хүчин чармайлт хорш бүхүүдийн эдийн засагт хүндээр туссаг ак.

Сүүлийн арван жилд Бээжингийн хамгийн бохир үйлдвэрүүдийг хотоос гаргаж, хорш Хэбэй муж руу шилжүүлсэн нь тэдэнйн агаарын чанарыг муутажээ. Гринписийн жилтэн Лори Милливорга "Энэ жил агаарын чанар сайжирсан нь энэхэн Бээжинд хамгийдэг бүй нь харамсалтай" хэмээн. Түүнчлэн Хятадын зарим бүсэд эдийн засгийн өсөлт сааран нь агаарын чанар дээшлэхэд нөлөөлжээ. Гэвч энэ жилээс өсөлт дээшлэхий үлмаас Хятадын хотуудын гурвны нэгд агаарын бохирдол дээшлэхийг Гринпис мэдээлэн байна.

Шинэ Делид насанда үзээгүй утаа тортог дунд амьдрч бүй хүмүүст агаар тур ч ятугай сайжрахад амсхийлт болдог гээ. Дели дэх Мэргэжлийн ба орчны эрүүл мэндийн төөнйн захирал нөөн Жёшн "Энэтхэгийн улстөрчид хөгжин хойнох агаарын бохирдлыг шийдэх гэх шиг хачин юм ярьдаг. Гэвч нийтийн эрүүл мэндэд хорионго оруулахгүй бол хөгжинө гэдэг үлгэр" гэжээ. Төрбээр цааш нь "Бохирын нйм асуудлаа маш сайн шийдсэн. Гэхдээ захиргадатлын дэлгэмд комьт хэмээх нь ардчиллаас хавьгүй хялбар. Ялангуяа асуудлын талаар хүн амын тал хувь нь ямар ч ойлголтгүй Энэтхэг шиг улсад бүр ч хүнд" хэмээн өгүүлсэн юм. FT

150 ХҮРТЭЛХ ХУНИЙ ШИНЭ ЖИЛИЙН ҮДЭШЛЭГИЙН ЗАХИАЛГА АВЧ БАЙНА.

Манай Орос тогоочийн бэлдсэн амтат зоог танай хамтын олны баярыг илүү амттай болгоно.

ШИНЭ ЖИЛИЙН ҮДЭШЛЭГИЙН УРАМШУУЛЛУУД

- Улаан хивс
- LED дэнлэц
- Үгталтын улаан дарс
- 4 цагийн заалны түрээс
- Хувцас солих нэмэлт өрөө
- Шинэ жилийн заалны чимэглэл
- Хөгжим аппаратур,
- гэрэлтүүлэг, дэнлэц, проектр, техникийн цогц шийдэл

Багц 1: 89'000 төгрөг

Багц 2: 99'000 төгрөг

Багц 3: 127'000 төгрөг

Үнийн дүнд 10% НӨАТ, 1% хөнөн татвар болон 5% үйлчилгээний хөлс орсон болно.

Захиалга авах утас:
+976 9905 0074
+976 9905 2015

Кемпински Хаан Палас Зочид буудал
У +976 11 463 463
и sales.uln@kempinski.com
kempinski.com/ulaanbaatar

Kempinski
ЗОЧИДЛОЛЫН ҮЙЛСЭН 1897

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [illegible]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. [illegible] is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Францын Нормандын ойролцоо байрладаг Жерси зэрэг оффшор бүсэд Их Британийн тэтгэврийн сан тогтмол хөрөнгө оруулдаг.

BBMC

Оффшор болгон буруугүй

Аттракт Мүүни

Долоохон хоногийн өмнө миний бие өөрийгөө Британийн хаант ёсыг хамгаалах чинээ бодсон ч үгүй явлаа. Paradise Papers-тэй холбогдуулан Хатан хаан Элизабетын татварын хэрэг хэвлэлийн тэргүүн нүүрэнд гарч байгаа нь шударга бус шүүмж гэдгийг хэлэхгүй байж тэвчсэнгүй.

Өнгөрсөн долоо хоногт Paradise Papers нэрээр нийтэд задарсан бичиг баримтад Хатан хааны эзэмшилд багтдаг Ланкастерын герцогын эзэмшил нь хоёр ч оффшор санд 10 сая фунт стерлингийн хөрөнгө оруулсныг илчилсэн.

Их Британийн Люксембург, Жерсид байрладаг тэтгэврийн санд, Оксфорд, Кембрижийн их сургууль Кайманы арлуудын санд хөрөнгө оруулсныхаа төлөө бүтэн долоо хоногийн турш хэвлэлийнхний бай боллоо. Тэтгэврийнхээ сангаар дамжуулан гадаадын сангуудад хөрөнгө оруулж явдгаа энгийн нэгдсэн вант улсын ажилчдын хэд нь мэддэг юм бол гэсэн бодол надад төрж байв.

Их Британийн тэтгэврийн сангууд нь Ирландад байрладаг биржийн сан, Люксембургийн нэгдсэн хөрөнгө оруулалтын сан, Жерсигээр Кайманы арлууд хүртэл тархсан төрөл бүрийн хувийн хөрөнгө оруулалтын сан, хедж сангуудад хөрөнгө оруулж ажилладаг.

Ажлын тэтгэврийн санд татвар ногдуулдаггүй учраас дээрх шиг сангууд татвараас бултах нь ховор үзэгдэл. Их Британийн хөрөнгө оруулагчид тус улсаас гадна байрладаг дээрх төрлийн сангуудад хөрөнгө оруулсныхаа төлөө хөнгөлөлт эдэлдэггүй. Зарим хөрөнгө оруулагч бага татвар төлөхийн тулд татварын хөнгөлөлттэй бүс ашиглаад байгаа нь өнөөгийн энэ олон хэрүүл маргааны шалтгаан. Гэтэл та бид оффшор санг нийтэд нь муу муухайгаар нь дүрсэлсээр байна.

Оффшор сан байх ёстой хууль зүйн учир шалтгаан бий. Хөрөнгийн сангийн удирдлагууд хөрөнгөө ашиглахад зориулан дэлхийн хэд хэдэн газарт суурь бааз байгуулдаг. Европын холбоогоор жишээ авъя. Хөрөнгийн сангийн удирдлага сангуудаа Люксембург, Ирландад байрлуулж, Европын холбооны хууль зүйн дагуу Их Британийг оролцуулаад нийт Европ тивд хөрөнгө борлуулна. Энэ нь арилжаа хийхийн төлөө гишүүн улс болгонд сан байгуулах нүсэр зардлыг хэмнэж буй хэрэг. Учир нь ийм зардлыг эргээд хөрөнгө оруулагчид л төлнө.

Хөрөнгө оруулагчдын хувьд оффшор сангийн голдуу тал нь хөрөнгөө оновчтой зарцуулахын тулд хамтрагчдын илүү өргөн хүрээ хамрах, зардал хэмнэх явдал. Улс болгонд тусад нь хөрөнгө оруулах нь үнэтэй, хугацаа шаардсан ажил. Харин бусад хөрөнгө оруулагч нартай хөрөнгөө нэгтгэж нэг сан үүсгэвэл нийт зардал үлэмж буурдаг.

Хөрөнгө оруулалтын сангууд татвар багатай газар ажиллах замаар багийг төлөөд байгаа учраас энэ тогтолцоо төгөлдөр бус гэдэг нь мэдээж. Гэхдээ татвар бага төлдгөөс нь болоод Google, Starbucks зэрэг компаниас зүгтгэдэг хүн ер нь хэр олон бол?

Оффшор сангуудад тулгардаг бас нэг "нүгэл" бол татварын хөнгөлөлт эдэлдэг, эс бөгөөс төлдөг татвар нь тодорхойгүй гэсэн шүүмж. Энэ нь хэрэг дээрээ сангууд төлөхгүй ч, хөрөнгө оруулагчид тус тусынхаа улсын хууль зүйд нийцүүлж татвар төлөх ёстой гэсэн хэрэг.

Өөрөөр хэлбэл, нэг компанийн төлөө хөрөнгө оруулагч давхар татвар төлөх ёсгүй. Ютай ч энэ аргаар татвараа шударга мэдүүлж, төлөх ёстойгоо шударга төлчихдөг хүмүүст тохирсон арга гэдгийг кампани өрнүүлэгч Tax Justice Network группийн захирал Жон Кристенсен анхааруулав.

Голдуу баян чинээлэг, нэр алдартай хүмүүс оффшор траст үүсгэж, түүнийгээ сангуудад хөрөнгө оруулахад ашиглаж байгааг тэрбээр онцлон дурдав. Ийм трастыг эзэмшигч бага юм уу огт татваргүй улсуудад компанийн бүтэцтэй байгуулдаг. Ийм учраас санд төвлөрсөн ашиг орлогод маш бага татвар төлөх юм уу эсвэл огт татвар төлөхгүй.

"Оффшор сан бол татварын тогтолцооны талаасаа төвийг сахисан бүс. Тэгэхлээр ийм сан ажиллуулж буй хүмүүс эх орондоо татвараа төлөхгүй байгаа нь л бидний хувьд зөвшөөрч болохгүй зүйл" хэмээн ноён Кристенсен тайлбарлав.

Татвараас чөлөөлөх нь байж болшгүй зүйл. Ийм хөнгөлөлт нь татвараас бултах явдлыг л өөгшүүлэхээс цаашгүй хэмээн татварын тогтолцоог ил тод болгохын төлөө кампанит өрнүүлэгч дээрх байгууллага үзэж байна.

Бэрхшээлийн гол нь өнөөгийн маргаан энгийн хадгаламжийг мартчихаад байгаа явдал. Ийм сан байдаггүй сэн бол маш олон хүн тэтгэврийн сан болоод хөрөнгө оруулсан бусад байгууллагаараа дамжуулан давхар татвар төлж явна. Учир нь энгийн хүмүүс татвараас бултаж мэдэхгүй. Харин жинхэнэ бултагчид хэзээд арга олно.

Дэлхийн тэтгэврийн тогтолцоо сулрах, хүмүүс хуучнаасаа илүүг хэмнэх шаардлагатай тулгарч буй үед та бид хадгалагчдыг номж дарамтлаад байж болохгүй. Ийм банкуудыг татвараас бултахад нь туслаад байгаа тогтолцоог хууль ёсны хадгаламжийн байгууллагуудын ашигладаг сангаас тусад нь ялгаж салгамаар байна.

FT

Alibaba ганц бие хүмүүсийн өдөр шинэ амжилт тогтоов

Луис Лукас

Alibaba групп ганц бие хүмүүсийн өдрөөр худалдааны аварга амжилт тогтоож, 25.4 тэрбум ам долларын наймаа хийв. Энэ нь Хятадын худалдан авагчид цаг тутамд нэг тэрбум ам доллар хэмжихүйц ухаалаг утас, гутал, уруулын будаг зэргийг худалдан авч байсан хэрэг юм.

Дэлхийн жижиглэн худалдааны түүхэнд агуу үйл явдал болж хувирсан энэ өдөр 777 сая ширхэг баглаа боодол тээвэрлэжээ. "Хятадын хэрэглээг шинээр тодорхойлох цаг ирлээ" хэмээн Хятадын технологийн группийн гүйцэтгэх захирал Даниель Жан өгүүлэв.

Ганц бие хүмүүсийн өдөр нь нь Хятадад хэрэглээ "дэлбэ үсэрсэн"-ий хэмжүүр болж байна. Alibaba компани 11.11 гэж бичигддэг ганц бие хүмүүсийн өдрийг АНУ-ын худалдааны хямдралын ямар ч өдрөөс хэд дахин аварга үйл явдал болгон хувиргасан юм. Тус компани эдүгээ дэлхийн хамгийн үнэтэй 10 компанийн нэг.

Бямба гарагт 168 тэрбум юанийн бараа бүтээгдэхүүн борлуулжээ. Инфляц, ханшийн зөрөөг үл тооцох тохиолдолд уг хэмжээ нь Alibaba компани байгуулагдсан 1999 оны дөрөвдүгээр сарын турш борлуулсан нийт хэмжээнд дөхүү байгаа юм. Арван худалдан авалт тутмаас есийг нь гар утаснаас хийжээ.

"Alibaba-гийн эдийн засагт аварга өдөр тохиолоо" хэмээн компанийн дэд гүйцэтгэх захирал Жо Цай тайлбарлав. Аварга байхаас нэрэлхэж байгаагүй тус компани 2036 он гэхэд хоёр тэрбум хүнд үйлчилж, дэлхийн тав дахь гол эдийн засгаас илүү томрох зорилго тавьжээ. Энэ онд нийт орлого нь 49-53 хувь өснө хэмээн Alibaba тооцоолов.

Тус компани энэ жил олон улсын зах зээл, дотоодын хөдөө нутагт илүү анхаарал хандуулж байна. Жишээ нь, Шиньдун мужийн фермер 400 мянган ширхэг нугасны өндөг борлуулсан нь Nike, Uniqlo, Nestle зэрэг брэндтэй өрсөлдөхөөр байгаа юм.

Жилийн өмнөх 18 тэрбум ам долларын амжилтыг энэ жил 25.4 тэрбум болгон эвдлээ. Өсөн нэмэгдэж байгаа борлуулалтын эрчийг Alibaba гаднаараа дөнгөж хүчрэх үү гэсэн асуултыг шинжээчид тавьж байлаа. Бараа бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогоор үнэлдэг аргаас татгалзах тухай тус компанийг үндэслэгч, гүйцэтгэх захирал Жэк Ма цухуйлгаж байв.

"Бараа бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогоор хэмждэг аргаас өөр аргад шилжиж буйн нэг илрэл нь энтертэйнмент" хэмээн Хонконг дахь PwC консалтинг компанийн захирал Том Бертинел өгүүлсэн юм. Энэ онд Alibaba компани онлайн худалдааг бодит дэлгүүрүүдтэй нэгтгэх замаар жижиглэн худалдаагаа өргөжүүлж, олон улсын зах зээлд гарахаар төлөвлөжээ.

Энэ жилийн худалдааны шоу арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан гала-концертын оролцогч Фаррел Уильямс, Австралийн кино жүжигчин Николь Кидман зэрэг од хятад хэлээр үг хэлэн мэндчилж байлаа. Худалдаанд энтертэйнмент хэв загвар нэхэж буйг онцлон өгүүлсэн ноён Жан интернет сүлжээнд 34 тэрбум видео бичлэг тоглуулсныг энд татсан юм. "Цахим худалдаанд энтертэйнмент, хүмүүсийн харилцаа хоёр улам бүр салшгүй болж байна" хэмээн тэрбээр анхааруулав.

FT

Болгоомж төрүүлж буй уулзалт

Жон Райд

Энэ долоо хоногт Дональд Трамп Родриго Дутертетэй уулзах үеэр АНУ-ын Ерөнхийлөгч Филиппиний маргаантай удирдагчид найрсаг хандах нь уу гэдгийг Зүүн өмнөд Азийн улсын иргэд мэдэхсэн хэмээн ярьж байна.

Зангидсан нударга бол ноён Дутертег тодорхойлдог дохио зангаа. Тэрбээр 2016 оны зургадугаар сард засгийн эрхэнд гарснаасаа хойш өрнүүлсэн мансууруулах бодисын эсрэг кампанит ажил олон мянган хүний амь насанд хүрэхэд байгааг хүмүүс ширүүн шүүмжилдэг. Ноён Дутерте өөрөө насандаа хүн хутгалж хороож байснаа баясан гараг сайрхаж орхилоо.

АНУ-д тахал мэт тархсан хар тамхины эсрэг тэмцлийг гол бодлогынхоо нэгээр тодорхойлсон ноён Трамп зангидсан нударга харуулах аваас Ерөнхийлөгчийн нь өрнүүлж буй мансууруулах бодисын эсрэг дайныг тус улсын өөрийн холбоотон асуудал болохгүй гэж филиппинчүүдэд ойлгуулсан хэрэг болно.

АНУ-Филиппиний харилцаа нь Ази тивд чухал үүрэгтэй. Гэхдээ Ерөнхийлөгчөөр сонгогдсоноосоо хойш ноён Дутерте хоёр улсын хамтарсан цэргийн сургуулилтын цар хүрээг хумьж, БНХАУ, ОХУ-тай дотносох замаар уламжлалт холбоотноосоо "хөндийрөх"-өө зарласан юм.

Гэвч ноён Трамп сонгуульд ялснаар "Хоёр тал зарим талаар төстэй болчих шиг санагдав. Ерөнхийлөгч Дутертегийн үг яриа хүртэл АНУ-д тал засан ялсан болж ирлээ" хэмээн Филиппиний их сургуулийн улс төрийн ухааны эрдэмтэн, профессор Херман Крафт өгүүллээ.

Филиппиний Ерөнхийлөгч Манила дахь Trump Tower-ыг босгосон Century Properties компанийн захирал Хосе Антониог ноён Трампыг сонгуульд ялахаас хэдэн долоо хоногийн өмнө АНУ-д тусгай үүрэг гүйцэтгэх элчээр томилсон. "Трамптай хувийн харилцаатай энэ хүн ноён Дутертед хэрэг болсон үед хоёр талыг холбож өгнө" хэмээн Филиппиний шинжээч, тоймч Боб Чанко тайлбарлаж байна.

АНУ-ын 71 настай тэргүүн, Филиппиний 72 настай удирдагч хоёрт төстэй тал мундахгүй.

Хоёул өнгөрсөн онд сүржин бодлого тунхагласан сонгуулийн дүнд гарч ирсэн. Аль аль нь бодлогогүй үг яриатай, тэр ч байтугай байхсайхгүй бүдүүлэг, хараал хэлчихдэг. Хоёулаа АНУ-ын өмнөх Ерөнхийлөгч Барак Обамад дургүй. Мансууруулах бодисын эсрэг өрнүүлж буй дайныг нь шүүмжилснийх нь хариуд ноён Дутерте түүнийг "янхны хүү" хэмээн дуудаж байсан удаатай.

Уруудан доройтож буй хэмээн өөрсдөө тайлбарладаг улс үндэстнээ аварна гэдгээ энэ хоёр хоёул зарласан. Хоёулаа эдийн засгийн өсөлтийн түлхүүр нь дэд бүтцэд хийх хөрөнгө оруулалт гэсэн бодолтой. Хоёр эрхэм бие биеэ "элсэг дулаан ойлголцож" тухай засаг захирганных нь төлөөлөгч хүртэл мэдэгдсэн.

"Филиппинд Дутерте, Трамп хоёр энд нөхөд болцоох байх. Популистинтернационализм энэ хоёрыг нэгтгэж өгнө. Аль аль нь өөрсдийгөө либерал үзэлт глобал элитүүдэд бусдгүүлчихсэнээр төсөөлдөг" хэмээн The Rise of Duterte номыг зохиогч, шинжээч Ричард Жавад Хэйдерман тайлбарлав.

Дональд Трампыг ялтай ч ноён Дутерте тус улсаас АНУ-тай тогтоосон холоо холбоог багасгаж, БНХАУ-тай нөхөрлөх замаар харилцаагаа тэнцвэржүүлэхээр оролддог. Гэхдээ Манила нь Өмнөд Хятадын тэнгис дэх зарим нутаг дэвсгэрийг булаацалдагч Бээжингийн цэргийн оролцоонд түгшин хэвээрээ.

Ноён Трамптай бизнесийн холбоо холбоотой Антониог элчээр томилсон нь филиппинчүүдийн дунд маргаан дагуулсан. Засгийн газрын ажиллагаанд бизнесийн ашиг сонирхол хутгалдаж, харилцааг тооцох ардчилсан, ил тод байх зарчим алдагдах айдас үүссэн"-ийг ноён Хэйдерман өгүүлж байна.

Ашиг сонирхлын зөрчил байхгүйг Century компани тайлбарласан. Trump нэрийг ашиглах эрхийг Trump Organization 2011 онд Century-д өгсөн ч барилгаас хувьцаа эзэмшдэггүй тус компани мэдэгдэв. Уг барилгын 94 хувийг ноён Трамп АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн үеэс бүр өмнө буюу 2015 оны есдүгээр сард зарсан.

Ноён Антонио "Засгийн газрын бус, бодлого үл тодорхойлох түвшинд, цалингүйгээр" элчийн үүрэг гүйцэтгэж, АНУ, Филиппиний бизнесийн бүлгийнхний харилцааг сайжруулахад анхаарч ажиллана гэдгийг Century-гийн төлөөлөгч тайлбарлав.

FT